



# СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

# МЭЭДЭЭ

№242 /451/

2022.01.09

Цаг үе, үйл явдал

## ЦЭРГИЙНХЭН ӨВӨЛЖИЛТ ХҮНДЭРСЭН СУМДЫН АЙЛ ӨРХИЙГ НҮҮЛГЭХЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЖ БАЙНА



Дорнод аймгийн зарим сумдад өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан БНМАУ-ын баатар, ЗХУ-ын 4 удаагийн баатар, маршал Г.К.Жуковын нэрэмжит Зэвсэгт хүчний 327 дугаар ангийнхан орон нутгийнхандаа нийгмийн хариуцлагын хүрээнд дэмжлэг үзүүлж байна. Аймгийн Онцгой комиссоос тавьсан саналын дагуу өвөлжилт хүндэрч, цасанд боогдсон зарим сумын айл өрхүүдийг нүүлгэн шилжүүлэхээр тус ангийн дөрвөн бүлэг томилогдон ажиллаж байгаа юм.

Өнөөдрийн байдлаар ахлах ахлагч Б.Отгонжаргалаар ахлуулсан алба хаагчид Дорнод аймгийн Булган суманд ажиллаж, цасанд боогдсон айл өрхүүдийг нүүлгэн шилжүүлж байна. Энэ талаар ахлах ахлагч Б.Отгонжаргал "Булган сум нь аймгийн төвөөсөө 50 гаруй км зайтай. Цас маш их орсон учраас нүүлгэх айлууддаа очиход хугацаа багагүй зарцуулж байна. Манай бүлэг долуулаа, бид өчигдрөөс эхлэн сум орон нутагт томилогдон ажиллаж байгаа" гэсэн мэдээллийг өглөө.

Мөн тус ангийнхан аймгийн төвд орсон их хэмжээний цасыг төрийн цэргийн бусад байгууллагуудтай хамтран цэвэрлэж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрдүүлсэнд аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн цахим хуудсаараа дамжуулан талархал илэрхийлжээ.

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-9	-20


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
37	22

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.468	3.475
EUR	3.700	3.720
CNY	507	510
RUB	47.50	48.20
JPY	26.20	26.50
KRW	2.81	2.83

### ЗУРХАЙ



2022.01.09 / ДАВАА ГАРАГ /  
БИЛГИЙН ТООЛЛЫН 18

**ӨВЛИЙН ДУНД ХАР ХУЛГАНА  
САР  
ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ  
УЛААГЧИН ТУУЛАЙ ӨДӨР**

**Үс засуулбал:**


**Эд малын гарлагатай  
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:  
08.40-17.18**

**Барилдлага:**

Рашаан  
**ШҮТЭН БАРИЛДАГА:  
САНСАР**

Тухайн өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Эл өдөр насны хүч дэлгэрнэ. Эм найруулах, угаал үйлдэх, бэр авах, насны авшиг, насны бүтээл хийх зан үйл хийгээд төрөл садан бололцох, худалдаа наймааны үйлнээ сайн болой, бурханы ёс ба тарни бүтээх, амраг нөхдийг хураахуйд сайн. Баруун чих хангинавал асрагдах, зүүн нь бол буян арвижих, нохой уливал гэрийн тэнгэр зайлсан, хэрээ гуаглавал эд агуурс олдох, тагнай загатнавал зочин ирэх, бие татвал гаслан болох, хөл татвал хувцас олдоно.

## ЭСЭЭ БИЧЛЭГИЙН УРАЛДААНД...



Зэвсэгт хүчин 2022-2023 оны сургуулийн жилийг "Залуу офицеруудын манлайлал"-ын жил болгосонтой холбогдуулан Агаарын цэргийн командлалаас тусгай төлөвлөгөө гарган ажиллаж байна. Тухайлбал, уг ажлын хүрээнд залуу офицеруудын дунд "Агаарын цэргийн хөгжилд залуу офицерын оролцоо" сэдвээр эсээ бичлэгийн уралдаан зарлаж шилдгүүдээ шалгарууллаа.

Уралдааны тэргүүн байрт Зэвсэгт хүчний 353 дугаар ангийн 324 дүгээр дивизийн салааны захирагч дэслэгч Т.Цолмон, дэд байрт Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн офицер, дэслэгч М.Хонгорзул, гутгаар байрт Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн 086 дугаар тусгай ротын салааны захирагч ахлах дэслэгч Б.Болдбаатар нар тус тус шалгарч бусад нөхдөө манлайлав.



## МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙН УУЛЗАЛТААР...



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч У.Хүрэлсүх 2023 оныг "Залуу офицерын манлайлал"-ын жил болгосонтой холбогдуулан Агаарын цэргийнхэн "Ахмад-Залуу үе 2023" мэргэжил арга зүйн уулзалтыг зохион байгуулав.

Уулзалтад Агаарын цэргийн командлалын удирдлага, ахмад дайчид, анги, салбаруудын залуу офицеруудын төлөөлөл оролцлоо.

Энэ үеэр ахмад дайчид залуу офицерууддаа хандаж хэлсэн үгэндээ эзэмшсэн мэргэжилдээ эзэн

нь байх, өөрийн үндсэн үүргээ алхам тутамдаа ухамсарлаж багаар ажиллах, удирдах, манлайлах, өөрийгөө болон захирагсдаа хүмүүжүүлдэг байх, хариуцсан салаа, салбарын сургалтыг чанартай удирдан зохион байгуулах, цаг хугацаатай уралдан ажиллаж, байнгын бэлэн байдлыг хангаж чаддаг байх зэрэг олон чухал сургамжийг захисан юм.

Тус уулзалт нь ахмад, залуу үеийн холбоог сайжруулж, харилцан мэдлэг, туршлагаа солилцох орчныг бүрдүүлсэн онцлог давуу талтай болж өндөрлөлөө.

## ХУГАЦААТ АЛБАНЫ ЦЭРГҮҮД АВЬЯАСААРАА ӨРСӨЛДӨВ



Ардын Хатанбаатар С.Магсаржавын нэрэмжит Цэргийн гавьяаны Улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн цэргийн гэрээт болон хугацаат алба хаагчдын дунд "Авьяаслаг салбар" урлагийн үзлэгийг зохион байгууллаа. Тухайлбал, мэндчилгээ, гоцлол дуу, хөгжим, хамтлаг дуу, бүжиг, уран уншлага, язгуур урлаг, хошин шог гэсэн 8 төрлөөр дайчид авьяасаа чадвараа сорин өрсөлдөхөд ахлах дэслэгч А.Төгөлдөр захирагчтай мотобуудлагын ротын хамт олон тэргүүлж, ахмад М.Мөнх-Учрал захирагчтай 82мм-ийн миномётын батарей, ахмад Б.Бадрал захирагчтай Зенит артиллерийн батарейны хамт олон тус тус удааллаа.

Дэд ахлагч П.МАНДАХЦЭЦЭГ

**КОРОНАВИРУС  
ДЭЛХИЙ ДАХИНД**

**Тохиолдол**

Нийт: 668,665,275

**Эдгэрсэн**

Нийт: 639,969,049

**Нас барсан**

Нийт: 6,713,730

Цахим шууданд

## ДЭСЛЭГЧ Ч.АМИН-ЭРДЭНЭ АХЛАГЧТАЙ БАГ ТЭРГҮҮЛЛЭЭ



БНМАУ-ын баатар хурандаа генерал Ж.Лхагвасүрэнгийн нэрэмжит Цэргийн гавьяаны одонт Зэвсэгт хүчний 167 дугаар анги, Цэргийн гавьяаны одонт Хилийн цэргийн 0131 дүгээр анги хамтын ажиллагааны хүрээнд уулзалт, сургалт, уралдаан тэмцээнийг зохион байгуулсаар байгаа билээ.

Энэ удаа Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагчид Хилийн цэргийн 0131 дүгээр ангид зочилж, хилийн албаны онцлогтой танилцаж, хоёр ангийн дайчид буухиа тэмцээнээр өрсөлдсөн юм.

Цэргийн нийтлэг дүрэм, танин мэдэхүйн асуулттай "АХА" тэмцээнийг Хилийн цэргийн 0131 дүгээр ангийн хамт олон зохион явуулахад тэргүүн байрт тус ангийн байлдагч Б.Мягмардорж, дэд байрт ахлах байлдагч У.Цэрэндэмбэрэл нар шалгарав.

Харин цэрэгжилтийн буухиа тэмцээний тэргүүн байрыг дэслэгч Ч.Амин-Эрдэнэ ахлагчтай Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн нэгдүгээр баг, дэд байрыг дэд ахлагч Б.Чулуунбаатар ахлагчтай хилийн цэргийн 0131 дүгээр ангийн хоёрдугаар баг эзэллээ.

Дэслэгч Б.БАТЗАЯА

## ЗЕНИТИЙНХЭН "ОФИЦЕРУУДЫН ХУРЛЫН ТАНХИМ"-ТАЙ БОЛЛОО

2023 оныг "Залуу офицеруудын санал бодлоо солилцох, ажлын бүтээмжээ манлайллын жил" болгон зарласантай дээшлүүлэхэд их чухал үүрэгтэй" хэмээгээд холбогдуулан Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн үлгэрлэн дагуулагч, манлайлагч байхын тулд



бие бүрэлдэхүүн "Офицеруудын хурлын танхим"-ыг засварлан тохижуулж, ашиглалтад орууллаа.

Өөрсдийн дотоод нөөц бололцоондоо тулгуурлан 20 гаруй хоногийн хугацаанд тохижуулсан бөгөөд засвар, үйлчилгээг ахлах ахлагч Д.Ганзориг тэргүүтэй зенитчид гүйцэтгэсэн юм. Танхимын нээлтийн үеэр ангийн захирагч, хурандаа Г.Отгонбаяр онцлон хэлсэн үгэндээ "Энэ төв нь цэргийн сургалт бэлтгэлийг чанартай зохион байгуулах, алба хаагчид өөрийгөө хөгжүүлж,

өөрийгөө хэрхэн бэлтгэх, юуг анхаарах тухай лекц уншсан юм.

Мөн энэхүү танхимын тохижилтод зориулж БНӨСУ-д явагдаж байгаа НҮБ-ын мандаттай энхийг дэмжих ажиллагааны XI ээлжийн цэргийн багт үүрэг гүйцэтгэсэн бүрэлдэхүүн шаардлагатай сандал, ус буцалгагч зэргийг хандивласан юм.

Ахмад Ц.ТУНГАЛАГ

## ДЕСАНТ ГАТЛАЛТЫН РОТЫНХОН МАНЛАЙЛЛАА



Цэргийн гавьяаны одонт Зэвсэгт хүчний 234 дүгээр анги 2023 оны "Туухай өргөлт", "Ширээний теннис"-ийн аварга шалгаруулах тэмцээнийг энэ сарын 05, 06-ны өдрүүдэд зохион байгуулж явууллаа.

Тэмцээнд эрэгтэй, эмэгтэй тамирчид 16, 24 кг жингийн туухайгаар огцом болон түлхэлттэй өргөлтөөр өрсөлдөж, нэгдсэн дүнгээр 60 кг жинд дэслэгч А.Айган, ахлагч Д.Төгсгэрэл, 70 кг жинд түрүүч Б.Эрдэнэбат, ахлагч Ч.Баярмагнай, 80 кг жинд ахлагч А.Эрхбаяр, ахлагч П.Батхүү, эмэгтэй төрөлд Б.Буянхишиг, дэд ахлагч Б.Отгонцэцэг нар шалгарч, тэргүүн болон дэд байрын эзэд боллоо.

Багийн төрлөөр явагдсан ширээний теннисийн тэмцээнд тэргүүн байрт Десант гатлалтын рот, дэд байрт Хөвүүр гүүрийн рот тус тус шалгарсан юм.

Дэслэгч Ч.ОЮУНЧИМЭГ



## СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Дорноговь аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабаас сумдын ЗДТГ-ын дарга, багийн засаг дарга, хэсгийн ахлагч нарын дунд "Цэргийн тоо бүртгэл", "Орон нутгийн хамгаалалт" сэдвээр сургалтыг зохион байгууллаа.

Сургалтын хүрээнд цэргийн штабын офицер хошууч Х.Энхсайхан "Батлан хамгаалах багц хуулиуд", "Цэргийн тоо бүртгэл", хошууч Б.Ууганбаасан "Орон нутгийн хамгаалалтын хууль эрх зүйн үндэслэл", "Орон нутгийн хамгаалалтын тухай хууль", Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн мэргэжилтэн Б.Болдсайхан "e-topologia ашиглаж цэргийн тоо бүртгэлд хамрагдах нь", Хууль эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Л.Оюунсүрэн "2023 онд хэрэгжиж эхлэх хууль эрх зүйн актууд" сэдвээр тус тус

хэлэлцүүлэг өрнүүлж бие бүрэлдэхүүнд мэдээлэл өгсөн юм.

Энэ үеэр аймгийн ЗДТГ-ын дарга Н.Хонгорзул, Цэргийн штабын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч хошууч Х.Энхсайхан нар цэргийн бүртгэлд шаардлагатай үзүүлэн таниулах материал, бичгийн хэрэгсэл, хуулийн гарын авлага зэргийг сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарт хүлээлгэн өгсний зэрэгцээ өнгөрсөн онд ажил үйлсээрээ манлайлсан тэргүүний "Батлан хамгаалах товчоо", "Засаг даргын Тамгын газрын дарга", "Багийн засаг дарга" нарыг Цэргийн штабын даргын өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.

Хошууч Б.УУГАНБААСАН

Сургалт

## МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №53

### ЧА ҮСГИЙН БҮТЭЦ, ЗӨВ, ЦЭВЭР БИЧИХ

ЧА бол дэвсгэр бус үсэг. Бүтэц зурлагын хувьд "сэрээ"-т үсэг юм. ЧА үсгийг бичихдээ үгийн эхэнд, зартиг буюу толгойтой нуруу зураад үзгээ салгаж, зүүн талаас нь хурц өнцөгтэй "сэрээ" зурлага гаргаж нуруунд нийлүүлдэг. ОЦМХ-ний Ц,Ч үсгийг монгол бичигт ганц энэ ЧА-гаар тэмдэглэдэг нь тэдгээрийг харилцан сэлгэж дууддагтай холбоотой юм. Өвөр Монголчууд зөвхөн ЧА-гаар хэлдэг бол Халх монголд Ч, Ц нь бие даасан авиа болжээ.

Уншигч та бүхэн үгийн эхэнд, дунд, төгсгөлд ордог ЧА, ЧЭ, ЧИ, ЧО, ЧУ, ЧӨ, ЧҮ гэж аялгуулан дуудаж үе үсэг хэрхэн хувирч буйг нүдлэн тогтоогоорой. Монгол хэлнээ ЦИ гэсэн үе байхгүй, ЧИ үе л байдаг.

Бичмэл тигээр:

